



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/158

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 9.12, 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Гэрэлтүүлэг засвар, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)  
Гишүүд: Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)  
Б.Пүрэвсүрэн (Нягтлан бодогч)  
Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын  
нярав)  
Д.Мөнх (Цахилгаан шугам сүлжээний салбарын  
эрхлэгч)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан нөхцөл хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (С.Төмөр)-д даалгасугай

3.Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас санхүүжүүлсэн гэрэлтүүлэг засвар, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх Засаг даргын тамгын өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН